



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Албан тушаалд сонгон шалгаруулах журам батлах тухай

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 03 сарын 04-ний "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" А/05 дугаар тушаалын 5.1, 5.2 дахь хэсэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн "Хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийн 5.7 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн "Албан тушаалд сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг байгууллагын хүний нөөцийн ажилтан(И.Тогооч)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Удирдлагын зөвлөлд даалгасугай.

ДАРГА

Х.ЧИРЧИНСҮРЭН



Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн  
даргын 2023 оны 07 сарын 21-ний өдрийн  
4/26 дугаар тушаалын хавсралт



## АЛБАН ТУШААЛД СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

- Энэхүү журмаар Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгт ажилд орох эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- Монгол улсын үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.
  - Энэхүү журмын зорилго нь эмнэлгийн хүний нөөцийг бүрдүүлэх, чадварлаг мэргэшсэн ажилтанг сонгон авч, ажиллуулах, байгууллагын үйл ажиллагааг чанаржуулахад оршино.
  - Сул байгаа орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлан, сонгон шалгаруулалтыг ил тод, шударгаар явуулна.
  - Шинэ ажилтанг сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна.
  - Тухайн сул ажлын байрны зар, тавигдах шалгуур, сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудсанд иргэдэд нээлттэйгээр хүргэнэ.

### Хоёр.Сонгон шалгаруулалтанд оролцогчдын бүрдүүлэх материал

/АУНЭмнэлэгт ажилд орохыг хүссэн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Төрийн албан хаагчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл үндсэн эхээр
- Зэрэг, цолыг тодорхойлсон баримт
- 3 үеийн намтар
- Зураг 4 хувь /3x4/
- Эрүүл мэндийн үзлэгийн хуудас, дэвтэр
- Анкет хийх хавтас 1ш

### ав. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын материалыг хүлээн авах

- УАУНЭмнэлгээс зарласан ажлын байранд 2-д заагдсан материалыг зар олсон олон нийтэд зарлагдсан өдрөөс ажлын 10 хоногийн дотор хүлээн авна.
- Хугацаа хэтэрсэн материалыг хүлээж авахгүй.

- Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан олгож цаашдын сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт**

- Сонгон шалгаруулалтын 1-р шатыг хүний нөөцийн хариуцсан албан хаагч зохион байгуулж, материалтай бүрэн танилцаж тэнцсэн иргэдийн материалыг байгууллагын даргад танилцуулна.
- Байгууллагын дарга тэнцсэн иргэдээс мэдлэг, ур чадварын шалгалт авах товыг тооцооно.
- Мэдлэг, ур чадварын шалгалтын комисс нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Их эмч, сувилагч нарыг сонгон шалгаруулах комисст

- Комиссын дарга: Байгууллагын дарга
- Гишүүд: тасгийн эрхлэгч, ахлах сувилагч
- Хүний нөөц
- Ёс зүйн багийн ахлагч

Томилогдсон комисс нь сонгон шалгаруулалтанд оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлэн сонгоно. Нийтлэг шалгаруултанд оролцогчдын хууль эрх зүй, харилцааны соёлыг / ярилцлагаар / гадаад хэлний мэдлэгийг / тусгай шалгуурт мэргэжлийн онолын мэдлэг / тестээр, ур чадварыг /гардан үйлдлээр/ үнэлнэ.

### **ав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх**

- Хүний нөөц нь оролцогчдын шалгаруултанд тэнцсэн болон тэнцээгүй тухай мэдээг холбогдох утсаар болон цахим хаягаар шат бүрийн дараа хүргэн, дараагийн шатанд урьж шаардлагатай мэдээллийг хүргэнэ.
- Ажилтан сонгон шалгаруулах комиссын дарга сонгон шалгаруултанд тэнцэн өндөр оноо авч, эхний 2 байранд тэнцсэн иргэдийг байгууллагын даргад танилцуулж, шийдийн дүгнэлтийг гаргана.
- Байгууллагын дарга шалгаруултанд тэнцсэн иргэнтэй хөдөлмөрийн гэрээг байгуулснаар сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусна.

### **ургаа. Бусад зүйл**

- Сонгон шалгаруулалтын явцыг баримтжуулсан материалыг хүний нөөцийн ажилтан архивт дараа оны 1 дүгээр улиралд шилжүүлнэ.
- Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдлыг хүний нөөц хүлээн авснаас хойш ажлын 1 хоногийн дотор шалгаруулалтын комисс шийдвэрлэнэ. Үйлголцолд хүрээгүй тохиолдолд байгууллагын удирдлагын багийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр мэдээлнэ.